

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН



УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТАМГЫН ГАЗАР

2025 ОНЫ 10 ДУГААР САРЫН 29-НИЙ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРОО

ЧУУЛГАНЫ ХУРАЛДААНЫ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дээрх
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2025 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ
ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ
ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**

2025 оны 10 дугаар сарын 29-ний өдөр, Лхагва гараг

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	1
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	2 – 5
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	6 – 28

1.	<i>Байнгын хорооны тогтоолын төсөл /Ажлын хэсэг байгуулах тухай/</i>	9 – 11
2.	<i>Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, “Үндэсний баялгийн сангийн тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2025.09.01-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ./</i>	11 – 28

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганы
Эдийн засгийн байнгын хорооны 10 дугаар сарын 29-ний өдөр
/Лхагва гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Эдийн засгийн байнгын хорооны дарга Р.Сэддорж ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 32 гишүүнээс 17 гишүүн хүрэлцэн ирж, 53.1 хувийн ирцтэйгээр хуралдаан 12 цаг 15 минутад Төрийн ордны “Их эзэн Чингис хаан” танхимд эхлэв.

*Томилолттой: Ц.Баатархүү, Ш.Бямбасүрэн, А.Ундраа;
Эмнэлгийн чөлөөтэй: Х.Булгантуяа, Г.Очирбат, Б.Тулга;
Тасалсан: Ж.Алдаржавхлан, О.Батнайрамдал, Н.Батсүмбэрэл,
Ж.Бат-Эрдэнэ, О.Цогтгэрэл.*

Хэлэлцэх асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Р.Батболд “Хянан шалгах түр хороо байгуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хойшлуулах гэсэн санал гаргав.

Р.Сэддорж: Улсын Их Хурлын гишүүн Р.Батболдын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 7
Бүгд: 17
58.8 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Хэлэлцэх асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Л.Соронзонболд Газрын тосны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хойшлуулах гэсэн горимын санал гаргав.

Р.Сэддорж: Улсын Их Хурлын гишүүн Л.Соронзонболдын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 8
Бүгд: 19
57.9 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Б.Жавхлангийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дэмжсэнээр тооцож, 63.2 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Нэг.Байнгын хорооны тогтоолын төсөл /Ажлын хэсэг байгуулах тухай/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын газрын Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Б.Ууганцэцэг нар байлцав.

Байнгын хорооны дарга Р.Сэддорж Байнгын хорооны тогтоолын төслийг танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Р.Сэддорж: Байнгын хорооны тогтоолын төслийг баталъя гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 17

Татгалзсан: 5

Бүгд: 22

77.3 хувийн саналаар Байнгын хорооны тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 12 цаг 32 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, “Үндэсний баялгийн сангийн тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2025.09.01-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ./

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга И.Батхүү, мөн яамны Төр, хувийн хэвшлийн түншлэлийн газрын дарга Т.Баясгалан, Хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Х.Сүрэнхорол, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Дашпүрэв, мөн яамны Уул уурхайн бодлогын газрын дарга Г.Намчинсүрэн, Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, мөн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хууль тогтоомж, гэрээ, эрх зүйн газрын дарга М.Үнэнбат, Нийслэлийн өмчит “Улаанбаатар түншлэл төв” ХХК-ийн гүйцэтгэх захирал З.Батырбек, “Төр, хувийн хэвшлийн түншлэлийн төв”-ийн захирал М.Амгаланбаатар нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын газрын Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, зөвлөх Л.Батмөнх, референт Б.Ууганцэцэг, Х.Шижирмөнх, М.Мандхай нар байлцав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэв.

-Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Төслийн 1 дүгээр зүйлийг хэлэлцэж дуусав.

-Төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Р.Сэддоржийн тавьсан асуултад Эдийн засаг, хөгжлийн яамны Төр, хувийн хэвшлийн түншлэлийн газрын дарга Т.Баясгалан хариулж, тайлбар хийв.

-Төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан санал гараагүй болно.

-Төслийн 2 дугаар зүйлийг хэлэлцэж дуусав.

-Төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Р.Сэддорж: Улсын Их Хурлын гишүүн М.Энхцэцэгийн гаргасан, Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн 6/13 дугаар зүйлийн 13.2 дахь хэсэг:

“13.2.Аймаг, нийслэл дараах салбарт түншлэлийн төслийг хэрэгжүүлж болно.” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн М.Энхцэцэг үг хэлж, Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга И.Батхүү, мөн яамны Төр, хувийн хэвшлийн түншлэлийн газрын дарга Т.Баясгалан нар тайлбар хийв.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 15
Бүгд: 22
31.8 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

-Төслийн 3 дугаар зүйлийг хэлэлцэж дуусав.

-Төслийн 4 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Төслийн 4 дүгээр зүйлийг хэлэлцэж дуусав.

-Төслийн 5 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Төслийн 5 дугаар зүйлийг хэлэлцэж дуусав.

-Төслийн 6 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Төслийн 6 дугаар зүйлийг хэлэлцэж дуусав.

Хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцэв.

Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн “Үндэсний баялгийн сангийн тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Пунсалмаа, Б.Жаргалан, Г.Лувсанжамц, Б.Уянга нарын тавьсан асуултад Сангийн сайд Б.Жавхлан, Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Уул уурхайн бодлогын газрын дарга Г.Намчинсүрэн нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүдээс санал гараагүй болно.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Р.Батболд Төсвийн байнгын хорооны хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 13 цаг 16 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 2 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 1 цаг 02 минут үргэлжилж, 32 гишүүнээс 21 гишүүн хүрэлцэн ирж, 65.6 хувийн ирцтэйгээр 13 цаг 17 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Р.СЭДДОРЖ

Тэмдэглэл хөтөлсөн:
ЧУУЛГАНЫ ХУРАЛДААНЫ
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

Ц.АЛТАН-ОД

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 оны 10 дугаар сарын 29-ний өдөр, Лхагва гараг
Төрийн ордны “Их эзэн Чингис хаан” танхим
12 цаг 15 минут

ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Р.Сэддорж: Байнгын хорооны эрхэм гишүүдийн энэ өдрийн амгаланг айлтгая.

Хуралдаанд оролцож байгаа гишүүдийг танилцуулъя.

Хуралдаанд Монгол Улсын Их Хурлын гишүүн Чинбаатарын Анар, Мягмарсүрэнгийн Бадамсүрэн, Ринчиндоржийн Батболд, Пүрэвийн Батчимэг, Жамбалын Ганбаатар, Пүрэвжавын Ганзориг, Болдын Жавхлан, Батбаярын Жаргалан, Батжаргалын Заяабал, Чулуунбилэгийн Лодойсамбуу, Бадрахын Найдалаа, Эрдэнэбилэгийн Одбаяр, Бадамдоржийн Пунсалмаа, Лхагвасүрэнгийн Соронзонболд, Ренчинбямбын Сэддорж, Саруулсайханы Цэнгүүн, Доржсүрэнгийн Үүрийнтуяа нарын гишүүд ирсэн байна.

Хуралдааны ирцийг танилцуулж дууслаа.

Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирж, Байнгын хорооны ирц 53.1 хувьтай бүрдсэн тул Эдийн засгийн байнгын хорооны 2025 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

Нэг. “Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл. Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсэг байгуулах тухай.

Хоёр. Газрын тосны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд. Улсын Их Хурлын гишүүн М.Бадамсүрэн нарын 7 гишүүн 2025 оны 7 дугаар сарын 09-ний өдөр өргөн мэдүүлсэн. Хэлэлцэх эсэх.

Гурав. “Хянан шал шалгах түр хороо байгуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл. Ухаахудаг ордын ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн асуудлаар Улсын Их Хурлын гишүүн Л.Оюун-Эрдэнэ нарын 33 гишүүн 2025 оны 10 дугаар сарын 06-ны өдөр өргөн мэдүүлсэн.

Дөрөв. Монгол Улсын 2026 оны төсвийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон “Үндэсний баялгийн сангийн тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл. Засгийн газраас 2025 оны 9 дүгээр сарын 01-ний өдөр өргөн мэдүүлсэн. Анхны хэлэлцүүлэг. Санал, дүгнэлтийг Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ.

Хэлэлцэх асуудал дээр өөр саналтай гишүүд байна уу? Хэлэлцэх асуудал дээр Газрын тосны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг хэлэлцэх асуудлаас хойшлуулах саналтай байна. Та горимын саналаа оруулах юм уу?

Өөр хэлэлцэх асуудал дээр саналтай хүн байна уу? Р.Батболд гишүүн.

Р.Батболд: Хэлэлцэх асуудлын тэр Хянан шалгах түр хороог байгуулах асуудлыг хэлэлцэх асуудлын дарааллаас хасаад хойшлуулмаар байна.

Тэгээд би нөгөө үндэслэлээ хэлье. Тэгэхгүй бол “Эм Си Эс”-ийн нохой гээд л алуулж өгөх байх.

Монгол Улсын Их Хурлын даргын захирамжаар 2025 оны 5 сарын 08-ны 210 тоот захирамжаар ажлын хэсэг байгуулагдаад ажиллаж байгаа юм. Энэ нь тодорхой ордыг стратегийн ач холбогдолтой гэж үзээд түүнтэй холбоотой Их Хурлын 2007 оны 27 дугаар тогтоолын хүрээнд ажиллаж байгаа ийм ажлын хэсэг байгаа.

П.Мөнхтулга гишүүнээр ахлуулсан ажлын хэсэг байгаа. Ажлын хэсэг нь өөрөө 11 гишүүнтэй. Ахлагч нь П.Мөнхтулга. Тэгээд Х.Баасанжаргал гишүүн, миний бие, О.Батнайрамдал гишүүн, Б.Бат-Эрдэнэ гишүүн, Э.Болормаа гишүүн, Ш.Бямбасүрэн гишүүн, С.Зулпхар гишүүн, Б.Жаргалан гишүүн, М.Нарантуяа-Нара гишүүн, Д.Пүрэвдаваа гэсэн бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг ажиллаад байгаа юм.

Тэгэхээр энэ ажлын хэсгийг байгуулах гэж бас сонирхол гэх юм уу, ашиг сонирхлын зөрчил байна уу, байхгүй юу гэж байж ажлын хэсэг байгуулахад жоохон хэцүү байсан. Олон гишүүн орж ирсэн. Тэгээд үүнээс татгалзаад гарсан гишүүд нэлээн хэд байгаа.

Ингээд Ажлын хэсэг байгуулагдаад бид шинжээч нарынхаа багийг томилоод ажиллуулж байгаа юм. Тухайн ажлын хэсэг ерөөсөө голчлоод Ухаа худагтай холбоотой асуудлуудыг л авч хэлэлцээд байгаа юм. Энэ дээр тухайн үед Хууль зүйн сайдаар ажиллаж байсан О.Алтангэрэлийн мэдээллийг бид ажлын хэсэг дээрээ сонссон байгаа.

Тэгээд дээрээс нь шинжээч нарынхаа багийг томилсон. Шинжээч нар нь өөрсдөө 3 чиглэлээр ажиллаж байгаа.

- Нэг нь, санхүүгийн чиглэлээр.
- Хоёрдугаарт нь, хууль эрх зүйн чиглэлээр.
- Гуравдугаарт нь, эдийн засгийн чиглэлээр

гэсэн ийм 3 чиглэлээр шинжээч нар ажиллаж байгаа.

Ажиллах хугацаанд Тамгын газраас цалин хөлснийх нь асуудлыг шийдэж өгөхгүй жоохон асуудалтай тулгараад байгаа.

Тэгэхээр одоо Хянан шалгах түр хороо байгуухаар энэ асуудал дээр Их Хурал нэг ажлын хэсэг, нэг Хянан шалгах түр хороо гэсэн ийм давхардсан ажил хийх гээд байна уу гэж хараад байгаа юм. Хуулиараа бол болох юм байна лээ. Тэгэхдээ үүнийгээ

- намын бүлгүүд нь яриад юм уу,
- даргын зөвлөл дээрээ яриад юм уу,
- өмнөх ажлын хэсгийг нь татан буулгаад юм уу,
- нэгтгээд явах юм уу?

Энэ асуудлаа шийдэж байж оруулж ирвэл яасан юм бэ гэсэн саналтай байна.

Р.Сэддорж: Санал хураалтад гишүүдийнхээ ирцийг бүрдүүлье. Ирц хүрэхгүй байгаа тул Эдийн засгийн байнгын хорооны хуралдааныг 1 цаг 30 минут хүртэл түр завсарлуулъя.

Сая Улсын Их Хурлын гишүүн Р.Батболд горимын санал гаргасан. Хэлэлцэх асуудалтай холбогдуулж.

Р.Батболд гишүүн гуравдугаар асуудлыг хойшлуулъя гэсэн санал гаргасан байна.

Р.Батболд гишүүний гаргасан горимын саналаар санал хурааа. Гишүүд санал хураалтад бэлдье.

Хэлэлцэх асуудлын жагсаалтаас “Хянан шалгах түр хороо байгуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл гэсэн гуравдугаар асуудлыг өнөөдрийн хуралдаанаас хойшлуулъя гэсэн саналыг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт. /алх цохив/

58.8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Л.Соронзонболд гишүүн горимын санал гаргаж байна.

Л.Соронзонболд: Өнөөдөр М.Бадамсүрэн гишүүний санаачлан оруулж байгаа Газрын тосны хуульд өөрчлөлт оруулах тухай асуудлыг ирц хангалтгүй

байгаа учраас хойшлуулах горимын санал гаргаж байна. Энэ дээр санал хурааж өгөөч ээ.

Р.Сэддорж: Хэлэлцэх асуудлын хоёрт байгаа Газрын тосны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг хэлэлцэх асуудлаас хасъя гэсэн горимын санал, хойшлуулъя гэсэн горимын санал гарсан байна.

Л.Соронзонболд гишүүний гаргасан горимын саналаар санал хураалтад бэлдье. Гишүүд.

Л.Соронзонболд гишүүний гаргасан горимын саналаар Газрын тосны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэх асуудлаас хойшлуулахыг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт. /алх цохив/

57.9 хувийн саналаар санал дэмжигдлээ. Б.Жавхлан гишүүнийг дэмжсэнээр протоколд тэмдэглүүлье.

Нэг. “Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл.

Энэ бол Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсэг байгуулах тухай.

Хоёр. Монгол Улсын 2026 оны төсвийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон “Үндэсний баялгийн сангийн тухай хуулийг хэрэгжүүлэх арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл гэсэн хоёр асуудлыг хэлэлцэх нь.

Хэлэлцэх асуудлыг баталъя.

Хэлэлцэх асуудал. Нэг. “Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцэж эхэлье.

Нэг.Байнгын хорооны тогтоолын төсөл
/Ажлын хэсэг байгуулах тухай/

Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсгийг 2025 оны 6 дугаар сарын 20-ны өдөр Улсын Их Хурлын гишүүн

О.Батнайрамдалаар ахлуулан Улсын Их Хурлын даргын 276 дугаар захирамжаар байгуулсан байсан.

Ажлын хэсгийн ахлагч О.Батнайрамдал гишүүн түр хорооны дарга болсон. Мөн ажлын хэсгийн 8 гишүүнээс Г.Лувсанжамц гишүүн Эдийн засгийн байнгын хорооны гишүүн байгаа. Бусад гишүүн нь өөр Байнгын хорооны гишүүд болсон тул энэ ажлын хэсгийг дахин шинэчилж байгуулах шаардлагатай болсон.

Байнгын хорооны даргын хувьд ажлын хэсгийн ахлагчид Улсын Их Хурлын гишүүн Пүрэвийн Батчимэгийн нэрийг дэвшүүлж байна.

Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орох хүсэлтэй гишүүд саналаа өгнө үү. Улсын Их Хурлын гишүүн С.Цэнгүүн, Улсын Их Хурлын гишүүн Б.Пунсалмаа, Улсын Их Хурлын гишүүн Л.Соронзонболд, Улсын Их Хурлын гишүүн Р.Батболд, П.Ганзориг гишүүн, Б.Уянга гишүүн, Д.Үүрийнтуяа гишүүн.

Ингээд Монгол Улсын Их Хурлын Байнгын хорооны тогтоолын төслийг уншиж танилцуулъя.

“Ажлын хэсэг байгуулах тухай”

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.5 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1 дэх хэсгийг үндэслэн Эдийн засгийн байнгын хорооноос ТОГТООХ нь:

1.Монгол Улсын Засгийн газраас өргөн мэдүүлсэн Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээ, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга"-ын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг Байнгын хороо болон чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл хангах, санал, дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай:

Ажлын хэсгийн ахлагч:

Улсын Их Хурлын гишүүн П.Батчимэг

Ажлын хэсгийн гишүүд:

Улсын Их Хурлын гишүүн	Л.Соронзонболд
Улсын Их Хурлын гишүүн	С.Цэнгүүн
Улсын Их Хурлын гишүүн	Б.Пунсалмаа
Улсын Их Хурлын гишүүн	П.Ганзориг
Улсын Их Хурлын гишүүн	Б.Уянга
Улсын Их Хурлын гишүүн	Д.Үүрийнтуяа

2.Ажлын хэсэгт мэргэжил арга зүйн туслалцаа авах, мэдээллээр хангах чиглэлээр холбогдох байгууллагын мэргэжлийн албан хаагчдыг хуралдаанд оролцуулахыг ажлын хэсэгт зөвшөөрсүгэй.

Эдийн засгийн байнгын хорооны дарга.

Ажлын хэсгийн бүрэлдэхүүн болон тогтоолын төсөлтэй холбогдуулан асуулт асууж, санал хэлэх Улсын Их Хурлын гишүүд байна уу? Алга байна. Гишүүд асуулт асууж, санал хэлж дууслаа.

Санал хураалт явуулъя. Гишүүд санал хураалтдаа бэлдье.

“Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг баталъя гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

77.3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Байнгын хорооны тогтоол батлагдлаа. “Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийн хэлэлцүүлэг дууслаа.

Дараагийн асуудалдаа оръё.

Хоёр.Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, “Үндэсний баялгийн сангийн тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2025.09.01-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ./

Хэлэлцэх асуудал. Хоёр. Монгол Улсын 2026 оны төсвийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон “Үндэсний баялгийн сангийн тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг хэлэлцэж эхэлье.

Ажлын хэсгийг оруулъя. Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийн анхны хэлэлцүүлэг.

Ажлын хэсгийг танилцуулъя.

Болдын Жавхлан Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд, Идэшийн Батхүү Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Буриадын

Дашпүрэв Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Төмөрийн Баясгалан Эдийн засаг, хөгжлийн яамны Төр, хувийн хэвшлийн түншлэлийн газрын дарга, Хаш-Эрдэнийн Сүрэнхорол Эдийн засаг, хөгжлийн яамны Хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Жамъяншаравын Дэлгэржаргал Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга, Гүнчинсүрэнгийн Намчинсүрэн Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Уул уурхайн бодлогын газрын дарга, Маамбын Үнэнбат Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хууль тогтоомж, гэрээ, эрх зүйн газрын дарга, Зулпайн Батырбек Нийслэлийн өмчит “Улаанбаатар түншлэл төв” ХХК-ийн гүйцэтгэх захирал, Монхоогийн Амгаланбаатар “Төр, хувийн хэвшлийн түншлэлийн төв”-ийн захирал.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10 дахь хэсгийг баримтлан хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцье.

Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгье. Алга байна. /алх цохив/

Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан гишүүдээс зарчмын зөрүүтэй санал ирүүлээгүй байна. /алх цохив/

Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгье.

Ер нь энэ хуультай холбогдуулан энэ хуулиар ямар өөрчлөлт шинэчлэлт оруулах гэж байна вэ? Үүнийгээ товч тодорхой хэлээч ээ. Хариулт хэдэн номер вэ? Гараа өргөөрэй. 5 номер.

Т.Баясгалан: Эдийн засгийн байнгын хорооны гишүүддээ өдрийн мэнд хүргэе.

Тэгэхээр Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуулийг дагалдуулан Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж, Засгийн газраас Улсын Их Хуралд 9 сарын 01-ний өдөр өргөн мэдүүлсэн байгаа.

Тэгэхээр хуулийн төслөөр дараах 4 цогц асуудалд нэмэлт, өөрчлөлт оруулахаар зорьсон байгаа.

► **Нэгдүгээрт нь,** өнөөдөр хуулийн 13.1 дүгээр зүйл, 2 дугаар зүйлд заасан шаардлагын дагуу улсын төсвөөс дотаци авдаг зарим аймгуудыг болон 100 мянган хүн амд хүрээгүй аймгуудыг түншлэлээр төсөл хэрэгжүүлэх боломжийг хаасан байсан.

Тэгэхээр үүнийг нээж өгөөд, хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төсөл хэрвээ батлагдах юм бол нийслэл нэмэх нь 21 аймаг ямар нэгэн улсын төсвөөс татаас авдаг, авдаггүйгээрээ ялгаварлахгүйгээр, мөн хүн амын тооныхоо хэмжээнээс үл хамаараад бүх 21 аймаг Төр, хувийн хэвшлийн түншлэлээр төсөл хэрэгжүүлэх боломжийг нээж өгч байгаа.

► **Хоёрдугаарт нь**, түншлэлийн төслийн урьдчилсан үнэлгээ бүрэн шинжилгээ хийх хугацаа байгаа.

Тийм учраас процессын хугацааг багасгах зорилгоор Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хуульд заасан байгаа урьдчилсан шалгаруулалт, уралдаант шалгаруулалт гэдэг сонгон шалгаруулалтын процессыг нэгтгэж нэг үе шаттай болгож, хугацааг товчилж хувийн хэвшлийн түншлэгчийг сонгон шалгаруулах боломжийг нээж өгч байгаа.

Мөн түншлэлийн төсөлд тавигдах нийтлэг болон тусгай шаардлагуудыг нэгтгэж нэгдсэн нэг шаардлага тавьдаг болгох өөрчлөлтийг оруулж байгаа.

Саяын тэр процесс дээр нэмээд хэлэхэд түншлэлийн төслийг санаачлахаас авхуулаад түншлэгчдийг сонгож гэрээ байгуулахын тулд хамгийн багадаа 8 үе шатыг дамжиж 12-оос 18 сарын хугацаа шаардагдаж байгаа энэ процесс, олон шат дамжлагыг цөөрүүлж байгаа.

Дараагийн нэг өөрчлөлт нь Сангийн яамтай холбоотой. Төр, хувийн хэвшлийн түншлэлийн төсөл дээр Сангийн яамнаас процесс ажиллагаан дээр 4 удаа зөвшөөрөл авдаг байсан тогтолцоог Сангийн яамнаас санал, дүгнэлт авдаг болгож өөрчилж байгаа.

Ингэснээрээ Төр, хувийн хэвшлийн түншлэлээр төсөл хэрэгжих ажлыг шуурхайлах, мөн Засгийн газарт танилцуулаад гэрээ байгуулах шийдвэрийг гаргасны үндсэн дээр Төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлэх төслүүдийн хэрэгжилт эрчимжиж, өнөөдөр эдийн засгийн нөхцөл байдалд үүсээд байгаа, мөн гадаадын хөрөнгө оруулалт, дотоодын хөрөнгө оруулагч компаниудын түншлэлээр төсөл хэрэгжүүлэх боломжийг өргөтгөх зорилгоор Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хуулийн нэмэлт, өөрчлөлт... /минут дуусав/

Р.Сэддорж: Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. /алх цохив/

Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан гишүүдээс зарчмын зөрүүтэй санал ирүүлээгүй байна. /алх цохив/

Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгье. Алга байна. /алх цохив/

Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан гишүүдээс зарчмын зөрүүтэй нэг санал ирүүлсэн байна. Саналыг уншиж танилцуулъя.

Аймаг, нийслэл, нийслэл нь бие даан цахилгаан эрчим хүч үйлдвэрлэх, эрчим хүчний шинэ эх үүсвэрүүдийн төслүүд, цахилгаан дамжуулах агаарын шугам, түгээх сүлжээний төлөвлөлтийг шийдвэрлэх нь Монгол Улсын эрчим хүчний системийг нэгдсэн төлөвлөлтгүй болгож, эрчим хүчний салбарт эдийн засгийн болон техникийн хувьд үр дүнгүй төлөвлөлт үүсгэх эрсдэлийг үүсгэж байна.

Түүнчлэн Эрчим хүчний тухай болон Сэргээгдэх эрчим хүчний тухай хуулийн үндсэн агуулга, зарчимтай зөрчил үүсгэж тухайн хуулиудыг хэрэгжүүлэхэд хүндрэл үүсгэх нөхцөлийг бүрдүүлсэн байна.

Саналын томъёолол.

Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн 3 дугаар зүйлийн 6.13 дугаар зүйлийн 13.2 дахь хэсэг “13.2 аймаг, нийслэл дараах салбарт түншлэлийн төслийг хэрэгжүүлэх болно.” гэснийг хасах.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн М.Энхцэцэг. М.Энхцэцэг гишүүн саналаа тайлбарлах уу? М.Энхцэцэг гишүүн.

М.Энхцэцэг: Байнгын хорооны гишүүддээ энэ өдрийн мэндийг хүргэе.

Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай одоогийн хууль дээр аймаг, нийслэл төр хувийн хэвшилтэй хамтраад бие даасан эрчим хүчний эх үүсвэрийг барих төслүүдийг өөрсдөө шалгаруулаад явах заалт орсон байдаг.

Энэ нь хоёр хязгаарлалттай байдаг.

- ➔ Нэг нь, тухайн аймаг улсын төсвөөс ямар нэгэн зээл сүүлийн 3 жилд аваагүй байх.
- ➔ Хоёр дахь нь, 100 мянган хүн амаас дээш байх гэсэн.

Гэтэл одоогийн өөрчлөлтөөр энэ хоёр өөрчлөлтийг байхгүй болгож орж ирж байгаа.

Тэгэхээр миний санал бол хуучин хоёр хязгаарлалтыг байлгах нь зүйтэй гэж үзэж байгаа.

Яагаад гэхээр эрчим хүчний системийн асуудал нэгдсэн төлөвлөлттэй явагддаг.

Тэгэхээр эрчим хүчний систем буюу Эрчим хүчний яамны оролцоогүй, Сангийн яамны оролцоогүй аймаг бие даагаад төр, хувийн хэвшлээр системийн тогтвортой ажиллагаа, дээрээс нь маш өндөр өртөгтэй тарифтай ийм эх үүсвэрийг бие даагаад бариад байх нь эрчим хүчний салбарт маш хор хөнөөлтэй.

Тийм учраас нэгдсэн төлөвлөлтийг алдагдуулж байгаа учраас тийм хязгаарлалтууд байх нь зүйтэй гэж үзэж байгаа.

Хоёрдугаар асуудал нь, яагаад гэвэл цахилгаан эрчим хүчний систем бол системийн хэмжээнд яригддаг нэгдсэн төлөвлөлттэй уялдаж явах ёстой. Зүгээр яах вэ, аймаг нийслэлийн хувьд дулаан хангамжийн асуудлаа өөрсдөө бие даагаад төр, хувийн хэвшлээрээ төсөл хэрэгжүүлээд явах нь бүрэн боломжтой байгаа.

Дараагийн нэг асуудал нь, аймаг, нийслэлүүд ямар ч хязгаарлалт байхгүйгээр төр, хувийн хэвшлээр бие даагаад эрчим хүчний эх үүсвэрүүд, сэргээгдэх, нар салхи гээд явахаар мэдээж тогтворжилтод нөлөөлж байгаа.

Хоёрдугаар асуудал нь, аймаг, нийслэлүүд дараагийн Хөгжлийн банк шиг болж эхэлж байгаа. Яагаад гэхээр Та бүхэн мэдэж байгаа. Улаанбаатар хотод нийслэл маань бие даагаад нэлээн олон эрчим хүчний төслүүдийг хэрэгжүүлсэн. Тэгэхдээ энэ маань нэг талаасаа үнэхээр зөв. Нөгөө талаасаа бид энэ дээр маш болгоомжтой хандах ёстой л доо.

Яагаад гэхээр нэгдүгээрт үнэ тариф нь батлагдаагүй, тэр худалдах худалдан авах гэрээ хийгдээгүй. Ингээд нэг том хувийн хэвшлийг шалгаруулдаг. Түүнийхээ дараа өндөр өртөгтэйгөөр. Тухайлбал, Улаанбаатар хотод баригдсан батарей бол бараг 16 цент гэдэг маш өндөр гэсэн үг. Гэтэл одоо эрчим хүчний системд хамгийн өндөр тариф 8.9 центтэй л байгаа.

Тэгэхээр цаашдаа хэрвээ аймгууд маань яг энэ байдлаар тэр 15, 16 центтэйгээр ийм сэргээгдэх эрчим хүч байна уу, батарей байна уу бариад явах юм бол энэ эрчим хүчний системийн асуудал маш хүндэрнэ.

Хоёрдугаар асуудал нь, бид цахилгаан эрчим хүчний зах зээлийг либералчлах тухай асуудал яригдаж байгаа. Цаашдаа өрсөлдөөнтэй болгоё гэж яригдаж байгаа. Хэрвээ бие даасан байдлаар аймгууд маань урт хугацаатай, өндөр тарифтай эх үүсвэрүүд, ялангуяа цахилгаан эрчим хүчний эх үүсвэрүүд бариад байх юм бол бид юун нөгөө цахилгаан эрчим хүчний зах зээлийг либералчлах асуудлыг хэрэгжүүлэх ямар ч боломжгүй болно.

Зүгээр дулаан хангамжийн хувьд нийслэл маань, аймаг маань өөрсдийнхөө асуудлыг төр, хувийн хэвшилтэйгээ хамтраад шийдээд явах бүрэн боломжтой.

Тэгээд саяын тэр хоёр хязгаарлалтыг байлгах нь зүйтэй юм гэдэг ийм саналын үндсэн дээр хуучин байгаа заалтыг нь хэвээр нь байлгаач ээ. Нийслэл болон аймаг маань эрчим хүчний эх үүсвэр барина. Гэхдээ хоёр хязгаарлалттай.

- Нэг нь, улсын төсвөөс буюу зээлгүй байх ёстой. Сүүлийн 3 жилд.
- Хоёрдугаарт, 100 мянган хүн амаас дээш хүн амтай байх ёстой гэсэн энэ хоёр хязгаарлалт нь хэвээрээ байх нь зүйтэй гэж үзэж байгаа.

Тэгэхээр гишүүд маань эрчим хүчний либералчлалыг цаашдаа хийнэ гэдэг дээр нэг байр суурьтай байгаа бол... /минут дуусав/

Р.Сэддорж: М.Энхцэцэг гишүүний гаргасан санал байгаа юм байна. Монгол Улс чинь эрчим хүчний хомсдолд орсон. Дулааны хомсдолд орсон байгаа даа.

Засгийн газраас нэг байр суурь сонсьё. 3 номер.

И.Батхүү: М.Энхцэцэг гишүүний асуултад хариулъя.

Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга И.Батхүү.

Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуульд оруулж байгаа нэмэлт, өөрчлөлтийн бас нэг гол агуулга нь аймаг, орон нутагт хэрэгжүүлэх боломжтой жижиг цар хүрээтэй нийгэм, эдийн засгийн хувьд тухайн орон нутагтаа үр ашигтай төслүүдийг зарим аймагт, эсвэл нийслэлд хэрэгжүүлэх боломжоор хязгаарлах нь орон нутгийн эрх ашиг нь тэгш байдлыг алдагдуулж байгаа гэж бас үзэж байгаа.

Яагаад гэвэл жишээ нь хог шатаах жижиг төслийг орон нутагт хэрэгжүүлэхэд эдийн засгийн хувьд бие даагаад хэрэгжүүлэх боломжтой байтал саяын дурдсан тиймэрхүү улсын төсвөөс өнгөрсөн хугацаанд дэмжлэг авч байгаагүй, 100 мянгаас дээш хүн амтай гэдэг шаардлагаар явахаар тэр нь орон нутагт амьдарч байгаа иргэдийн хувьд бас эрх ашиг нь зөрчигдөх нэг ийм эрсдэл байгаа. Энэ нь “тэгш байдлыг хангая” гэдэг үүднээс орж байгаа.

Хоёрдугаарт нь, Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийг хэрэгжүүлэхэд хамгийн гол шийдвэр гаргагч нь хувийн хэвшлийн хөрөнгө оруулагч байдаг.

Хувийн хэвшлийн хөрөнгө оруулагч нь өөрөө хуулийн, эрх зүйн, бусад төрлийн, байгаль орчинд нөлөөлөх нөлөөлөл гээд олон талын дүн шинжилгээ хийдэг. Англиар бол DUE DILIGENCE гэж ярьдаг. Энэ дүн шинжилгээний хувьд ямар нэгэн байдлаар эрсдэлтэй гэж үзэх юм бол хувийн хэвшил маань өөрөө хөрөнгө оруулалт хийхгүй. Төсөл хэрэгжихгүй. Бодит байдал дээр ийм үр дүн гардаг.

Өнгөрсөн хугацаанд Төр, хувь хэвшлийн түншлэлийн тухай хууль батлагдахаас өмнө Концессын тухай хууль гэж байхад олон тооны концессын гэрээ байгуулагдаад төсөл нь хэрэгжиж эхэлдэггүй, урьдчилсан нөхцөл нь хангагддаггүй тийм тохиолдлууд их гарч байсан.

Шалтгаан нь яг ийм байгаа. Яг үндсэн хөрөнгө оруулагч маань тухайн төсөлд дүн шинжилгээ хийгээд үзэхээр эргээд хөрөнгө оруулалтаа нөхөх нь баталгаагүй, хууль эрх зүйн хувьд тодорхой биш, эрсдэлтэй асуудлууд байсан учраас төслүүдийн үйл ажиллагаа нь саатдаг байсан.

Дээр нь нэмээд сэргээгдэх эрчим хүчний төслүүдийн хувьд өнгөрсөн хугацаанд гарсан хөрөнгө оруулагчтай гарч байгаа гол маргааны шалтгаан нь Эрчим хүчний зохицуулах хороотой байгуулсан цахилгаан худалдах, худалдан авах гэрээнд үнийн тарифын өндөр байгаа гэдэг асуудлууд байгаа. Орон нутагт хэрэгжих эрчим хүчний төслүүд маань эх үүсвэрийн хувьд шинээр хэрэгжүүлж эхлэх төслүүд дээр шинэ хуулийн үйлчлэл явагдах учраас олон улсын байдлаар, техник технологийн хөгжлийг дагаад сэргээгдэх эрчим хүчний төслүүдийн өртөг нь өөрөө буураад байгаа юм. 1 киловатт цаг нь бүр 2 цент хүртэл буурсан тийм тохиолдлууд тодорхой бүс нутгуудад уралдаан шалгаруулалтаар хөрөнгө оруулалтын шинэ гэрээнүүд байгуулагдсан тохиолдлууд байж байгаа.

Тэгэхээр энэ дээр орон нутгуудад шинэ төрлийн цахилгаан эрчим хүчний эх үүсвэрийг бий болгох боломжууд нээгдэнэ гэж үзэж байгаа.

Таны хэлж байгаа цахилгаан дамжуулах сүлжээ бол төрийн өмчлөлд байх ёстой. Стратегийн ач холбогдолтой. Түгээх сүлжээн дээр бас хөрөнгө оруулалтаа эргэж нөхөх нь тодорхой хэмжээнд бэрхшээлтэй байдаг учраас хөрөнгө оруулагчдын хувьд Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн шинэ зохицуулалтаар эх үүсвэр талдаа, ялангуяа сэргээгдэх эрчим хүч, дээр нь нэмээд хог шатаах гэдэг ч юм уу шинэ төрлийн шинэ технологийн шийдлүүдийг нэвтрүүлсэн төсвүүд дээр хэрэгжүүлэх бүрэн боломж хангагдана гэж үзэж байгаа.

Тэгээд дээр нь хуулийн заалтаар орон нутгаас төсөл хэрэгжүүлэлт огт хязгааргүй, хараа хяналтгүй хэрэгжүүлнэ гэсэн үг бас биш. Яг хуулийн заалтыг манай Төр, хувийн хэвшлийн түншлэлийн газрын дарга тодорхой хэлээд өгөх байх. Т.Баясгалан дарга.

Р.Сэддорж: 5 номер.

Т.Баясгалан: М.Энхцэцэг гишүүний асуултад хариулъя.

Тэгэхээр 3 дугаар зүйлтэй холбоотой зарчмын зөрүүтэй санал гаргаж байна гэж ойлголоо.

Энэ дээр 9.1.4, 9.1.5 дээр хуулиар нэмэлт, өөрчлөлт оруулж байгаа. Өөрөөр хэлбэл түншлэлийн төслийнх нь санхүүжилтийнх нь хэлбэрээс нь хамаараад мэдээж түншлэлээр төсөл хэрэгжүүлж байгаа этгээд зардлаа хэрэглэгчийн төлбөр хураамж болон төслийн орлогоор санхүүжүүлж байгаа тохиолдолд Сангийн ямаар хянуулаад санал, дүгнэлт авахаар, түншлэлийн төслийн зардлыг түншлэлийн гэрээнд заасны дагуу төсвөөс санхүүжүүлэх, эсвэл холимог хэлбэрээр санхүүжүүлэх тохиолдолд заавал Сангийн яамнаас зөвшөөрөл авч байж Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх зөвшөөрөл олгох өөрчлөлтийг хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төсөлд тусгасан байгаа.

Хэрвээ зөвшөөрөхгүй байх юм бол үндэслэл тайлбараа түншлэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ гэсэн ийм заалт оруулсан байгаа учраас энэ дээр аймаг, нийслэл, мөн... /минут дуусав/

Р.Сэддорж: 1 минут өгье. 5 номер гүйцээгээд хариулъя.

Т.Баясгалан: Тийм. Ийм байгаа учраас аймгууд бие даагаад юм уу, Сангийн яамны зөвшөөрөлгүйгээр шууд төсөвт үзүүлэх нөлөөлөл, эрсдэлийн тооцоо, шинжилгээгээ хянуулахгүйгээр түншлэлийн гэрээ байгуулах боломжийг хязгаарласан байгаа юм.

Р.Сэддорж: М.Энхцэцэг гишүүн яах юм? Хэлэлцүүлэг биш. Гэг л удаа яах юм байна. М.Энхцэцэг гишүүн тайлбарлах юм байна. Та 4 минут тайлбарласан юм байна.

Тэгээд зарчмын зөрүүтэй санал дээр Засгийн газраас, Төр, хувийн хэвшлийн түншлэлийн байгууллагаас тодорхой хариултууд хэллээ.

Тэгээд эдийн засгийг солонгоруулах, эдийн засгийг тэлэхэд энэ хуулийн өөрчлөлтийг бүгд л хүлээж л байгаа л даа. Тэгээд тэр сэргээгдэх эрч эрчим хүчийг тусад нь ойлгох ёстой байх. Сэргээгдэх эрчим хүч дээр маш өндөр тарифтай гэрээ хэлцэл. Түүнээс болоод л өнөөдөр Эрчим хүчний яам хүнд байдалтай л байгаа шүү дээ.

Гишүүд санал хураалтад бэлдье. М.Энхцэцэг гишүүний гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт. /алх цохив/

31.8 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 4 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгье. Алга байна. /алх цохив/

Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 4 дүгээр зүйлтэй холбогдуулан гишүүдээс ирсэн зарчмын зөрүүтэй санал ирүүлээгүй байна. /алх цохив/

Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 5 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгье. Алга байна. /алх цохив/

Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 5 дугаар зүйлтэй холбогдуулан гишүүдээс зарчмын зөрүүтэй санал ирүүлээгүй байна. /алх цохив/

Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 6 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгье. Алга байна. /алх цохив/

6 дугаар зүйлтэй холбогдуулан гишүүдээс зарчмын зөрүүтэй санал ирүүлээгүй байна. /алх цохив/

Одоо “Үндэсний баялгийн сангийн тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн хэлэлцүүлгийг явуулж эхэлье.

Ажлын хэсэг хэвээрээ. Тогтоолын төсөлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгье.

Улсын Их Хурлын гишүүн Б.Пунсалмаагаар тасалъя. Улсын Их Хурлын гишүүн Б.Пунсалмаа.

Б.Пунсалмаа: Гишүүдэд энэ өдрийн амар амгаланг айлтгая.

“Үндэсний баялгийн сангийн тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл хэлэлцэгдэж байгаа юм.

Тэгээд энд танилцуулга гарсан байна лээ. Танилцуулгаас хэдэн юм асууя гэж бодож байна. “Эрдэнэс Тавантолгой” ХК уул уурхайн биржийн тухай хуулиар 2023 онд 176 орчим цахим арилжааг амжилттай хийсэн. 3.1 орчим тэрбум долларын арилжааг 29.4 сая тонн нүүрсээр арилжааг хийсэн байгаа юм.

Гэтэл энэ жилийн экспорт, валютын орлогыг нэмэгдүүлэх зорилгоор 1 тэрбум ам.долларын үнийн дүнтэй нэг удаагийнх нь 3-аас 5 удаагийн нүүрсний том арилжаа хийнэ гээд танилцуулга дээр орж ирсэн байгаа юм.

Тэгэхээр эндээс миний асуулт. Яагаад өмнө нь 170 гаруй орчим удаагийн цахим арилжааг амжилттай зохион байгуулчихаад энэ удаадаа 3-аас 5 удаагийн. Нэг удаагийнх нь 1 тэрбум ам.долларын үнийн дүнтэй арилжаа зохион байгуулах гээд байгаа юм бэ? Ийм хэт том дүнтэй арилжаа зах зээлийн бус, уул уурхайн хямд бүтээгдэхүүний гэрээ байх магадлалтай болоод байгаа юм.

Тэгэхээр үүнийг ямар процессоор зохион байгуулах гэж байгаа юм? Ямар хугацаанд энэ асуудлыг зохион байгуулах вэ гэдгийг Уул уурхайн яамнаас байна уу? Тийм ээ. Эрдэс баялгийн яамнаас ч юм уу асууя.

Хоёрдугаар нь, 1 тэрбум долларын 3-аас 5 удаагийн арилжааг амжилттай зохион байгуулбал түүний дэнчинд зориулаад 250-иас 350 тэрбум ам.долларыг Монгол Улсад татан төвлөрүүлэх бололцоотой гэсэн байгаа юм. Энэ ер нь алдаатай юм ороод ирэв үү? Монгол Улсын эдийн засгаас хэд дахин том дэнчин урьдчилгаа орж ирнэ гэсэн ийм өгүүлбэр орж ирсэн байна лээ. Энэ танилцуулга дээр.

Энэ талаар мэдээлэл авъя.

Р.Сэддорж: 2 номер Г.Намчинсүрэн дарга. Уул уурхайн яам. Дараа нь Эдийн засаг, хөгжлийн яам бэлдэж байгаарай.

Г.Намчинсүрэн: Гишүүний асуултад хариулъя.

Аж үйлдвэрийн, эрдэс баялгийн яамны Уул уурхайн бодлогын газар. Г.Намчинсүрэн.

“Эрдэнэс Тавантолгой” болон бусад төрийн болон орон нутгийн өмчтэй аж ахуйн нэгжүүд уул уурхайн бүтээгдэхүүний биржийн хуулийн 12-т заасны дагуу экспортод гаргах бүтээгдэхүүнийг заавал биржээр арилжаалах зохицуулалттай.

Одоогоор Тавантолгой ордын Цанхийн хэсэг дээр “Эрдэнэс Тавантолгой” компани үйл ажиллагаа явуулж байна. Ашиглалтад бэлтгэгдсэн Бортээгийн хэсэг гэж бий. Үүний техник, эдийн засгийн үндэслэл 2021 онд батлагдсан байдаг. Төсөл 30 жилийн хугацаанд хэрэгжээд 290.0 орчим сая тонн нүүрс борлуулах техник, эдийн засгийн үндэслэлтэй.

Их Хурлын тогтоолоор бид энэ ордыг ашиглах асуудлыг л оруулж ирж байгаа юм. Борлуулах асуудал нь тэртээ тэргүй биржийн хуульд заасныхаа дагуу зохицуулалтууд нь ороод явах ийм эрх зүйн орчинтой байгаа.

Р.Сэддорж: 1 номер нэмж хариулъя. Сангийн яам.

М.Санжаадорж: Сангийн яам. М.Санжаадорж. Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга.

Тэр танилцуулга дээр байгаа тоотой хэсэг. Танилцуулга нь Эдийн засаг, хөгжлийн яам, Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас боловсруулж орж ирсэн байгаа. Тэгээд тоог нь бид алдаатай тоо бичсэн юм болов уу гэж бодож байгаа.

Түүнээс биш 250-иас 350 тэрбум доллар чинь хэдэн их наяд болох вэ дээ.

Р.Сэддорж: Б.Пунсалмаа гишүүн тодруулж асууя.

Б.Пунсалмаа: Гол нь миний санаа нь яагаад ийм том дүнтэй арилжаа 3-аас 5-хан удаагийн арилжаа зохион байгуулах гэж байна аа?

Өмнө нь 170 гаруй орчим энгийн зах зээлийн зарчмаар арилжаа хийж байсан. Үүнийгээ бөөгнүүлээд цөөхөн тооны арилжаа хийнэ гэдэг чинь энэ чинь оффтейк гэрээтэй ижилхэн ч юм шиг харагдаад байгаа юм л даа. 2022 оны үед чинь бид бас оффтейк гэрээгээр нүүрсээ экспортод гаргаад тэгээд валют орж ирдэггүй байсан. Сүүлдээ үүнийг биржийн арилжаагаар явуулах нь зөв юм гээд шийдсэн.

Тэгэхээр энэ удаагийн шийдлээр дахиад биржийн арилжаанаасаа ухрах шийдэл ч юм шиг харагдаад байна л даа. Энэ талаар асуугаад байгаа юм.

Р.Сэддорж: Сангийн сайд Б.Жавхлан.

Б.Жавхлан: Түрүүн Уул уурхайн яамны залуу хэллээ. Би тэр дээр. Гишүүний асуусан асуулт дээр нэмэлт мэдээлэл өгье.

Энэ бол яг эргэлтэд оруулах асуудлаа л шийдэж байгаа юм. Арилжааны хэлбэр бол бид энэ хуульдаа ямар ч өөрчлөлт оруулахгүйгээр одоо үүнийг дагасан тэр нөгөө уул уурхайн биржийн тухай хуульд өөрчлөлт оруулсан ямар ч тийм зүйл байхгүй учраас энэ маань юу гэсэн үг вэ гэхээр борлуулалт маань яг биржийнхээ хуулиараа л явна. Хуулиараа. Тийм. Энэ шинээр эргэлтэд оруулах эх үүсвэрээ л нэмж байгаа гэсэн үг.

Р.Сэддорж: Улсын Их Хурлын гишүүн Б.Жаргалан.

Б.Жаргалан: Чоно борооноор гэдэг шиг тэгээд л дахиад л Засгийн газраас хүмүүсийн анхаарал сарнисан байхад, улс төрчид нь хэрээс хэтэрсэн байхад төсвийн хуулиа дагалдуулаад Тавантолгой бүлэг орд дээр гэрээ байгуулах эрх өөрсдөдөө шилжүүлж авах тогтоолын төсөл оруулаад ирж байгаа.

Үүн дээр хүмүүс анхаарч байгаа юм уу, анхаарахгүй байгаад байгаа юм уу? Өнөөдөр л лав Эдийн засгийн байнгын хорооны хэлэлцүүлэг дээр Сангийн яам болон Уул уурхайн яамны хоёр газрын дарга л сууж байна. Өөр хэн ч алга. Тэр сайд нар нь хаачсан юм? Эдийн засаг, хөгжлийн сайд нь хаачсан юм. Сангийн сайд нь байдаг юм байгаа биз. Тэр Уул уурхайн яамны чинь сайд хаачсан юм. Ийм байдлаар энэ асуудалд хандах юм бол нээрээ маш харамсалтай байна.

Нүүрсийг нь хэн хулгайлсан юм. Өнгөрсөн хугацаанд “Эрдэнэс Тавантолгой” гэдэг компанийн борлуулсан 160 орчим сая тонн нүүрсний гэрээ болгон ил болоогүй байгаад байгаа.

Гэтэл Засгийн газар нь бид бүх нууц гэрээгээ ил болгосон гээд л Пи Ар хийгээд л байх юм, мэдэгдэл хийгээд байх юм. Гэтэл тэр гэрээнүүд нь хаана байгаа юм бүү мэд.

Тэгээд би сая нэг дэх өдөр Ерөнхий сайд Г.Занданшатарт хаяглаад Эрдэнэс Тавантолгойн орд газар дээр хийгдсэн, “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн хийсэн бүх нүүрсний гэрээг ил болго өө. Мэдэгдэл хийснийхээ дагуу. Тэгж байж олон нийт, хэвлэл мэдээлэл, бусад бүх хүмүүс чинь хэн нь худлаа яриад байгаа юм, хэн нь үнэн яриад байгааг ойлгомоор байна гээд шаардлага хүргүүлсэн байж байгаа.

Тэгээд өмнөх хулгай зэлгээнүүдэд нь эзэн олдоогүй баахан том дүнтэй тоонууд яригдаад байгаа энэ цаг мөч дээр дахиад Тавантолгой бүлэг ордын ашиглагдаагүй байгаа хэсгийг эдийн засгийн эргэлтэд оруулна. Иж бүрэн цогцоор нь ашиглах талаар олборлолт, тээвэрлэлт, экспортыг гүйцэтгэх хамтрагч, хөрөнгө оруулагчдад санал болгож, хэлцэл хийнэ гэсэн эрхийг авах ийм тогтоол оруулаад ирж байгаа байхгүй юу.

Тэгээд ашиглагдаагүй байгаад байгаа гэдэг хэсэг дээрээ та нар яг ямар гэрээ байгуулах гээд байгаа юм? Тэгээд тэнд чинь хэн хариулах юм? Б.Жавхлан сайд хариулах юм уу? Энэ хөрөнгө оруулагч нь хаана байгаа юм? Олборлолт, тээвэрлэлт, экспортыг нь бүгдийг нь нэг хөрөнгө оруулагч талд санал болгох юм уу?

Тэгээд энэ бүх зүйлд чинь хариулт авч байж үүнийгээ цааш нь яримаар байна шүү дээ. Тэгээд хариулт өгөх ч хүн байхгүй. Тэгээд нэг ийм бүдүүн баараг. Би чуулган дээр энэ талаар асуухад Н.Учрал сайд юу ярьсаар байгаад дууссан бэ гэхээр 1.4 буюу бүлэг ордын үйл ажиллагаанд олон улсын стандартыг нэвтрүүлнэ гэсэн зүйл ярьсаар байгаад л дууссан.

Тэгэхээр би ахиад Байнгын хорооны гишүүддээ бас уриалмаар байна. Энэ тогтоолыг бид баталж болохгүй. Эхний ээлжид өмнө нь хийгдсэн тэр бүх гэрээ хэлцлүүддээ дүн шинжилгээ хийгээд хаана нь хулгай зэлгий явсан юм. Ер нь энэ Эрдэнэс Тавантолгойг яах талаар шийдвэр гаргачхаад... /минут дуусав/

Р.Сэддорж: 2 номер хариулах уу? 2 номер хариул. Ямар юу хийх гээд байгаа юм. Хариуцсан хүн нь байж байна шүү дээ. Тэгээд сайдуудыг дуудъя. Энэ хажууд Төсвийн байнгын хороо хуралдаад байна. Давхардаж хуралдаад байна. Сайдуудыг дуудъя.

Г.Намчинсүрэн: Б.Жаргалан гишүүний асуултад хариулъя.

Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам. Г.Намчинсүрэн. Уул уурхайн бодлогын газар.

“Эрдэнэс Тавантолгой” ХК-ийг Засгийн газрын зүгээс нээлттэй хувьцаат компани болгох талаар чиглэлийг баримталж ажиллаж байгаа.

Сая онцгой дэглэм тогтоосон хугацаанд компанийг нээлттэй болгох талаар талуудыг оролцуулсан нээлттэй хэлэлцүүлгүүдийг зохион байгуулсан. Монгол Улсын Ерөнхий сайдаас энэ компанийг нээлттэй болгох чиглэлээр холбогдох ажлуудыг зохион байгуул гэдэг үүргүүдийг өгч яваа.

Яг цогцоор нь гэдэг асуудал дээр бас нэмэлт тайлбар өгөх шаардлагатай байх. Энэ ашиглагдаагүй байгаа хэсэг дээр байгаа нүүрс маань өөрөө гуравны нэг коксжих, дээрээс нь үнс өндөртэй нүүрс байгаад байгаа. Тэгээд чулууны үетэй.

Тэгэхээр энэ дээр мэдээжийн хэрэг бас давхар баяжуулалт дагалдаад үйлдвэрлэлийн асуудлууд явагдаж байж бүтээгдэхүүнийг нь экспортод гаргах боломжтой гэж үзэж байгаа.

Р.Сэддорж: Б.Жаргалан гишүүн.

Б.Жаргалан: “Эрдэнэс Тавантолгой” ХК гэдэг бол бас Монгол Улсын иргэн бүр 1072 хувьцаа эзэмшдэг. Тэр нь ерөөсөө амилж өгдөггүй. Тухайн шийдвэрүүд нь огт гараагүй байгаад байгаа байгууллага болчихоод байгаа.

Тэгээд хэрэв Засгийн газраас “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийг бирж дээр арилжаалах ч гэдэг юм уу. Тийм ээ. Тийм аргаар жинхэнэ утгаараа хувьцаат компани болгоно гэсэн тийм санал санаачилга байгаа бол ийм тогтоол оруулж ирэхийн оронд эхний ээлжид тэр компаниа нээлттэй болгоод, тэгээд тэр компанийнхаа хөгжлийн төлөвлөгөө энэ тэрийг танилцуулсны ар дээр дараа нь янз бүрийн гэрээ байгуулъя, ашиглагдаагүй байгаа эсэхээ ашиглая гэж яримаар байгаа байхгүй юу.

Эс бөгөөс ирээдүйд юу хийгдэх нь тодорхойгүй, ямар арга замаар яаж нээлттэй болгох нь тодорхойгүй байгаа нөхцөлд ашиглагдаагүй байгаа эсэхээ ашиглаад нэг том том хэлцлүүд хийгээд урьдчилгаа мөнгө авъя гэсэн ийм зүйл оруулж ирж болохгүй ээ.

Тэгэхээр бүү дэмжээрэй.

Р.Сэддорж: Улсын Их Хурлын гишүүн Г.Лувсанжамц.

Г.Лувсанжамц: Өдрийн мэнд хүргэе.

Б.Жаргалан гишүүн тэгээд санал нэг байна. Эхлээд уг нь сайд нь орж ирээд үүнийгээ тайлбарламаар байна. Төсөв дагуулж байгаад Их Хурлаар өөрөөр нь тогтоол гаргаж байгаад дахиад нэг ямар зорилготой гэдэг нь мэдэгдэхгүй ажлыг өөрсдөө эрхийг нь авч байгаад хийгээд явдаг. Нүүрсний хулгай хийдэг гээд л хүмүүсийг хэлээд байгаа. Энэ тогтоолыг харах юм бол Засгийн газар нь өөрөө хийх гээд байгаа юм биш үү? Тэгж харагдаж байна.

➤ Эхний асуулт. Орон сууцын хүртээмжийг нэмэгдүүлэх арга хэмжээ авах гээд 1.1 дээр бичсэн байна. Энэ жилийн хувьд асууя. Төрийн өмчид байгаа уул уурхайн компаниудын Үндэсний баялгийн сан дээр тэр дундаа ипотекийн эх үүсвэр дээр бүрдүүлж байгаа эх үүсвэр хэдэн төгрөг болж байгаа вэ? Яг одоогийн байдлаар.

➤ Хоёрдугаарт нь, 1.2 дээр цогцоор нь ашиглах талаар олборлолт, тээвэрлэлт, экспортыг гүйцэтгэх хамтрагч, хөрөнгө оруулагчдад санал болгож гэж байгаа юм. Энэ дотоодын аж ахуйн нэгжүүдийг хэлж байна уу, гаднын аж ахуйн нэгжүүдийг хэлж байна уу?

➤ Гуравдугаарт нь, 1 тэрбум долларын үнэ үнийн дүнтэй 3-аас 5 удаагийн нүүрсний том арилжааг амжилттай зохион байгуулсан тохиолдолд гэсэн зүйл байна. Ийм том үнийн дүнтэйгээр гэрээ хийхээр манай нүүрсний үнэ унахгүй юу? Бид яагаад биржийг бий болгосон юм.

Өрсөлдөөнийг бий болгоод аль болох их хэмжээгээр тонн тутмын үнийн дүнг өндөр байдлаар борлуулъя гэсэн зорилготойгоор Биржийн тухай хуулийг баталсан. Том үнийн дүнгээр цөөхөн удаа гэрээ хийхээр орлого, үнэ буурах биш үү? Энгийн логигоор бодоход. Энэ гурван асуултад хариулт авъя.

Р.Сэддорж: Уул уурхайн яам. Дараа нь Сангийн яам. 2 номер.

Г.Намчинсүрэн: Г.Лувсанжамц гишүүнтэй санал нэг байна. Бидний хувьд биржийн арилжааг идэвхжүүлэх замаар л бүтээгдэхүүнийхээ үнийг нэмэгдүүлэх боломжтой.

Тухайлах юм бол энэ оны 6 сард “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн хувьд 1.2 сая хавьцаа тонн нүүрс биржээр арилжаалсан байсан. Арилжаа нэлээн олон удаагийн арилжаа амжилтгүй болсон. Биржийн арилжааг нэлээн түлхэж өгөөд идэвхжүүлснээр дагаад бүтээгдэхүүний маань үнэ тодорхой хэмжээний өөрчлөлтүүд ороод нэмэгдэх хандлага гарч эхэлсэн.

Сүүлийн 3 сарын хугацаанд нүүрсний үнэ бирж дээр бага хэмжээгээр ч гэсэн дээшээ өндийх хандлагатай байгаа.

Тэр том арилжааны асуудлын тухайд түрүүн Сангийн яамнаас М.Санжаадорж дарга бас хэлэх шиг боллоо. Тэгээд танилцуулга дээр бас нэг жоохон алдаа гарсан байх л гэж бодож байна. Тийм.

Р.Сэддорж: 1 номер.

М.Санжаадорж: Сангийн яам. М.Санжаадорж. Гишүүний асуултад хариулъя.

Хуримтлалын сан буюу ипотект зарцуулах ёстой энэ санд 2025 оны байдлаар 507.1 тэрбум төгрөг төвлөрөхөөр байгаа. Ирэх 2026 онд бид 528.9 тэрбум төгрөг нэмж төвлөрнө гэсэн байдлаар тооцсон байгаа. Энэ нь нийлээд 1 их наяд 36 тэрбум төгрөг болно.

Р.Сэддорж: Улсын Их Хурлын гишүүн Б.Уянга.

Б.Уянга: Өдрийн мэнд хүргэе.

Өнөөдөр уг нь Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамнаас биш “Эрдэнэс Монгол”-оос л хүмүүс яг энэ тогтоолтой холбоотой хариулт өгч байх ёстой. Аж үйлдвэр, эрдэс баялгийн яаман доор “Эрдэнэс Тавантолгой”-н асуудал байхгүй шүү дээ. Яах вэ мэргэжлийн хүрээнд Г.Намчинсүрэн дарга өөрийнхөө үүргийн хүрээнд хариулаад явж байх шиг байна.

Тийм учраас уг нь яг энэ тогтоолыг “Эрдэнэс Тавантолгой”-нхонтой ярих хэрэгтэй байгаа юм. Гэхдээ нэгэнт хэлэлцээд эхэлсэн учраас өөрийнхөө өнцгөөс асуултуудыг тавья.

Монгол Улсын Их Хурлын тогтоол гарах нь ээ. Энэ “Эрдэнэс Тавантолгой”-той холбоотой, ашиглалттай холбоотой. Энэ төсөл орж ирлээ. Үндсэн миний асуулт нь ийм тогтоол гарах яг шаардлага байгаа юм уу?

Ингээд 2 зүйлтэй, 4 заалттай нэг ийм тогтоол байна л даа. Тийм ээ. Эхнээс нь харъя.

1.1 дээр Тавантолгойн бүлэг ордыг ашиглаагүй хэсгийг нь ашиглая гэж байгаа юм. Ашиглаач ээ гээд “Эрдэнэс Тавантолгой” байгаа шүү дээ. Тэр олон ашиглалтын тусгай зөвшөөрлүүд олгогдсон.

“Оорцог”, “Бортээг” гээд Тавантолгойн бүлэг ордын ашиглаагүй хэсэг гэсэн байгаа байхгүй юу. Тэгтэл нэг хэсэг чинь “Бортээг” гээд л явлаа даа. Тийм ээ. Энэ “Бортээг” гэсэн нэг үсэг, үг алга. “Оорцог”, “Бортээг” гээд хоёр хэсэг байгаа. Урьдчилсан хайгуул хийсэн.

Тэгэхээр “Эрдэнэс Тавантолгой” байсан бол би

- ▶ ашиглалтад ороход бэлэн юм уу?
- ▶ нарийвчилсан хайгуул нь явсан юм уу?
- ▶ ТЭЗҮ нь хийгдсэн юм уу?

гээд асуумаар байгаа байхгүй юу. Гэхдээ би Г.Намчинсүрэн даргаас асуумааргүй байна. Яагаад гэвэл өөрийнх нь яг 100 хувь харьяалж байгаа зүйл биш.

“Бортолгой”, “Онч хараат” хоёр дээр эрлийн л ажил хийсэн. Энэ нэг жилд хийгдэхгүй ээ. Энэ 2026 онд хийгдэхгүй. Тэгээд ямар учраас энэ тогтоол орж ирж байгаа юм? 1.1 дээр л лав ямар ч юм харагдахгүй байна.

1.2 дээр түрүүн Б.Пунсалмаа гишүүн ч хэллээ, Б.Жаргалан гишүүн ч хэллээ, Г.Лувсанжамц гишүүн ч хэллээ.

Энэ оффтейк гэрээний талаар л яриад байх шиг. Урт хугацааны гэрээний үндсэн дээр гээд. Эхнийхээ асуудлуудыг бүгдээрээ цэгцэлье л дээ. Тэгээд л дуртайгаа сошиал дээр хулгайч гэж цовдлоод л байж болохгүй.

Тэгэхээр үүний дараа л үүнийг ярих ёстой юм шиг.

1.3. Ингээд цаашлаад яваад байна шүү дээ. Тийм ээ. Ил тод, нээлттэй, үр ашигтай Их Хурлын тогтоол гаргаад засаг руу чиглэл авах гээд байгаа.

- Хэн нь ил тод битгий хий гээд байгаа юм?
- Тэгээд ер нь юмыг ил тод хийдэггүй юм уу?
- Үр ашигтай хийдэггүй юм уу?

Тэгэхээр энд 1.3 байх шаардлагагүй өгүүлбэр байхгүй юу.

1.4 дээр олон улсын аудитын байгууллагаар хянуул. Үгүй ээ, тэгээд тэр эрх чинь байгаа шүү дээ. Эрдэнэт дээр олон улсын аудит орж л байгаа шүү дээ. Тэгээд л тэр болгондоо Улсын Их Хурлаас чиглэл авахгүй л байна шүү дээ.

Энэ бол ерөөсөө 2026 онд гарлаа ч хэрэгжихгүй байхгүй юу. Хэзээ хайгуул нь хийгдэж дуусах юм. Тэгээд юу ч мэдэхгүй нэг хэдэн хүмүүс. Энэ бол Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны бэлдэж өгсөн тогтоол ч гэж би бодохгүй байна.

Тэгээд “Эрдэнэс Тавантолгой”-нхон, “Эрдэнэс Монгол”-ынхныг суулгаж байгаад үргэлжлүүлээд хариулаад асуух ёстой байх.

Р.Сэддорж: Б.Уянга гишүүн ээ, Төсвийн байнгын хороонд одоо хэлэлцэж байгаа юм байна. Тэнд нарийн асууж болох юм байна.

Энэ санал, дүгнэлт чинь Төсвийн байнгын хороонд хэлэлцэгдэнэ. Тэр үеэр давхар асууж болох юм байна.

Өөр хариулт байгаа билүү? Энэ дээр. Хариулт байгаа юм уу?

Би бас энэ “Эрдэнэс Тавантолгой”. Б.Уянга гишүүнтэй санал нэг л байна л даа.

Энэ тэр компани чинь ашиглах гээд л лицензийг нь эзэмшээд л байж байгаа биз дээ. Тийм ээ? Тэгээд ашиглагдаагүй гэдэг нь ямар учиртай юм бол? Тийм. Үүнийг тодорхой хариулах уу? Г.Намчинсүрэн дарга. 2 номер.

Тийм. Яагаад ашиглахгүй байгаа юм? Яагаад тусгай тогтоолоор яаж байгаа юм. Тийм ээ. Энэ талаар 2 номер. Юуг хэлээд байгаа юм? Тэр үлдэгдэл хэсэг гэж.

Г.Намчинсүрэн: Тавантолгойн орд маань өөрөө

- ▷ “Цанхи”,
- ▷ “Бортээг”,
- ▷ “Онч-Хараат”
- ▷ “Бортолгой”,
- ▷ “Оорцог”,
- ▷ “Ухаахудаг”

гэсэн хэсгээс бүрддэг.

Яг одоогийн байдлаар Ухаахудаг болон Цанхийн хэсэг дээр ашиглалтын үйл ажиллагаа явагдаж байгаа.

Бортээгийн хувьд нарийвчилсан хайгуулын ажил хийгдээд техник, эдийн засгийн үндэслэл 2021 онд манай яамны дэргэдэх Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлөөр батлагдсан байдаг.

Бусад хэсэг дээр эрэл үнэлгээний шатын түвшинд судалгааны ажил хийгдсэн байгаа. Ашиглах боломжтой гэж үзээд 2021 онд техник, эдийн засгийн үндэслэлийг нь баталсан Бортээгийн хэсэг гэж бий.

Р.Сэддорж: Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. /алх цохив/

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс зарчмын зөрүүтэй санал ирүүлээгүй байна.

Монгол Улсын 2026 оны төсвийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон “Үндэсний баялгийн сангийн тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулж дууслаа. /алх цохив/

Хууль, тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Эдийн засгийн байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ринчиндоржийн Батболд Төсвийн байнгын хорооны хуралдаанд танилцуулна.

Эдийн засгийн байнгын хорооны өнөөдрийн хэлэлцэх асуудал дуусаж байна. Хуралдаан өндөрлөснийг мэдэгдье. Хуралдаан идэвхтэй оролцсон гишүүд ажлын хэсгийнхэнд баярлалаа. /алх цохив/

Хуралдаан 1 цаг 02 минут үргэлжилж, 13 цаг 17 минутад өндөрлөв.

**БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ**

Ц.АЛТАН-ОД